



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2023/35/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баруун-Урт сум 2023 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: М.Нарантуяа Утас: 70518396 Аудитын менежер: Г.Даваа Утас: 70512123 Аудитор: А.Мөнхцэцэг Утас: 70512127</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 Завсрын аудитын талаар.....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 Төлбөрийн акт	16
5.2 Албан шаардлага.....	16
5.1 Зөвлөмж	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

**СҮХБААТАР АЙМГИЙН БАЙГАЛЬ
ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГА О.БАТНАСАН ТАНАА**

2023.02.24 № *70*

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Аймгийн Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 39 арга хэмжээг 500.0 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 36 төсөл арга хэмжээг 439.8 сая төгрөгөөр гүйцэтгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Сүхбаатар аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 13 зорилтын хүрээнд 76 арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилт 95 хувьтай үнэлэгдсэн байна.

D:/Bichig hereg/2023/A4 toot

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>17,464,120.00</u>	<u>21,931,239.00</u>
33	АВЛАГА	5,000,000.00	-
335	Бусад авлага	5,000,000.00	-
3351	Байгууллагаас авах авлага	5,000,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	12,464,120.00	21,931,239.00
354	Хангамжийн материал	11,864,120.00	21,931,239.00
35410	Бичиг хэргийн материал	2,674,450.00	9,260,569.00
35420	Аж ахуйн материал	2,325,790.00	3,650,790.00
35470	Бусад хангамжийн материал	6,863,880.00	9,019,880.00
35600	Мал амьтад	600,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>330,727,014.27</u>	<u>368,436,082.03</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	330,727,014.27	368,436,082.03
392	Биет хөрөнгө	178,311,014.27	213,903,082.03
39201	Барилга, байгууламж, орон сууц	18,611,936.00	18,611,936.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(2,768,220.42)	(3,990,682.74)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	96,679,960.00	101,266,627.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(30,967,767.22)	(45,653,982.55)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	67,548,536.00	101,927,216.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(35,088,103.11)	(24,101,290.55)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,063,195.00	23,100,002.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(3,521,514.61)	(3,656,207.60)
39214	Бусад үндсэн хөрөнгө	62,820,785.00	62,820,785.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(10,067,792.37)	(16,421,320.53)
393	Биет бус хөрөнгө	152,416,000.00	154,533,000.00
39301	Програм хангамж	970,000.00	2,383,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(970,000.00)	(266,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	152,416,000.00	152,416,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>348,191,134.27</u>	<u>390,367,321.03</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>348,191,134.27</u>	<u>390,367,321.03</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	348,191,134.27	390,367,321.03
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	161,183,515.00	161,183,515.00
51101	Өмч: - төрийн	161,183,515.00	161,183,515.00
512	Хуримтлагдсан үр дүн	186,875,755.27	229,051,942.03
51210	Өмнөх үеийн үр дүн	186,875,755.27	186,875,755.27
51220	Тайлант үеийн үр дүн	-	42,176,186.76
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	131,864.00	131,864.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>348,191,134.27</u>	<u>390,367,321.03</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	715,161,358.00	889,659,098.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	431,958.00	11,463,559.00
120	Нийтлэг татварын бус орлого	431,958.00	11,463,559.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	364,406.00	11,430,059.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	364,406.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		11,430,059.00
120009	Бусад орлого	67,552.00	33,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	714,729,400.00	878,195,539.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	130,703,000.00	22,769,139.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	7,343,000.00	20,062,539.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	119,000,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,360,000.00	2,706,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	584,026,400.00	855,426,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	584,026,400.00	855,426,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	724,634,435.03	847,478,160.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	724,634,435.03	847,478,160.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	704,614,319.09	834,897,824.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	301,425,142.44	317,888,045.26
210101	Үндсэн цалин	223,919,715.11	237,660,706.98
210102	Нэмэгдэл	48,631,094.79	49,631,559.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,655,458.24	11,288,269.65
210104	Урамшуулал	19,218,874.30	19,307,508.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,715,114.62	39,087,262.48
210201	Тэтгэврийн даатгал	27,041,488.16	27,126,126.65
210202	Тэтгэмжийн даатгал	3,014,251.37	3,188,169.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,411,400.96	2,558,167.21
210204	Ажилгүйдлийн даатгал	567,998.59	564,981.84
210205	Эрүүл мэндийн даатгал	5,679,975.54	5,649,817.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,954,007.00	11,784,269.00
210301	Гэрэл, цахилгаан	185,334.00	625,699.00
210302	Түлш, халаалт	7,813,693.00	9,875,250.00
210303	Цэвэр, бохир ус	679,980.00	923,320.00
210304	Байрны түрээс	275,000.00	360,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,676,200.00	15,613,248.00
210401	Бичиг хэрэг	2,319,600.00	3,385,389.00
210402	Тээвэр, шатахуун	7,178,520.00	10,092,085.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,321,971.00	1,044,984.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,856,109.00	1,090,790.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,862,488.00	5,181,470.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,562,488.00	289,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	300,000.00	-
210604	Урсгал засвар	-	4,892,470.00
2107	Томилолт, зочны зардал	4,132,400.00	10,717,000.00
210702	Дотоод албан томилолт	4,132,400.00	10,717,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,907,467.00	13,033,299.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,150,632.00	12,100,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	115,025.00	128,525.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	22,000.00
210807	Газрын төлбөр	291,810.00	432,774.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	312,941,500.03	421,593,230.85
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	282,514,993.00	381,375,140.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	320,000.00	2,144,850.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	30,106,507.03	38,073,240.85
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,020,115.94	12,580,336.26
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,429,415.00	7,971,576.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,429,415.00	7,971,576.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	14,590,700.94	4,608,760.26
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,590,700.94	4,608,760.26
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(9,473,077.03)	42,180,937.15
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	4,750.39
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	4,750.39
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(4,750.39)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(9,473,077.03)	42,176,186.76

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	716,161,358.00	878,229,039.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	431,958.00	33,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	431,958.00	33,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	364,406.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	364,406.00	-
120009	Бусад орлого	67,552.00	33,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	715,729,400.00	878,195,539.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	131,703,000.00	22,769,139.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	7,343,000.00	20,062,539.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	120,000,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,360,000.00	2,706,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	584,026,400.00	855,426,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	584,026,400.00	855,426,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	701,141,558.00	813,872,039.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	701,141,558.00	813,872,039.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	680,121,442.06	801,291,702.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	301,425,142.44	315,661,489.25
210101	Үндсэн цалин	223,919,715.11	235,434,150.97
210102	Нэмэгдэл	48,631,094.79	49,631,559.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,655,458.24	11,288,269.65
210104	Урамшуулал	19,218,874.30	19,307,508.75

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,715,114.62	39,111,711.49
210201	Тэтгэврийн даатгал	27,041,488.16	27,109,790.22
210202	Тэтгэмжийн даатгал	3,014,251.37	3,186,247.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,411,400.96	2,556,629.66
210204	Ажилгүйдлийн даатгал	567,998.59	569,004.08
210205	Эрүүл мэндийн даатгал	5,679,975.54	5,690,040.37
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,954,007.00	11,796,869.00
210301	Гэрэл, цахилгаан	185,334.00	625,699.00
210302	Түлш, халаалт	7,813,693.00	9,875,250.00
210303	Цэвэр, бохир ус	679,980.00	935,920.00
210304	Байрны түрээс	275,000.00	360,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,721,530.00	16,108,483.00
210401	Бичиг хэрэг	2,904,930.00	2,681,384.00
210402	Тээвэр, шатахуун	7,178,520.00	11,258,625.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,459,471.00	1,044,984.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,178,609.00	1,123,490.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,776,488.00	9,281,470.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,476,488.00	289,000.00
210604	Урсгал засвар	300,000.00	8,992,470.00
2107	Томилолт, зочны зардал	4,132,400.00	10,230,000.00
210702	Дотоод албан томилолт	4,132,400.00	10,230,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,536,467.00	13,233,299.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,757,632.00	12,300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	115,025.00	128,525.00
210807	Газрын төлбөр	291,810.00	432,774.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	284,860,293.00	385,868,381.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	284,540,293.00	383,723,531.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	320,000.00	2,144,850.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,020,115.94	12,580,336.26
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,429,415.00	7,971,576.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,429,415.00	7,971,576.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,590,700.94	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,590,700.94	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	4,608,760.26
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	4,608,760.26
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	15,019,800.00	64,357,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	15,019,800.00	64,357,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,019,800.00	64,357,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	15,019,800.00	64,357,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	15,019,800.00	64,357,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(15,019,800.00)	(64,357,000.00)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	93,094,515.00	1,703,523.00	(47,717,113.27)	47,080,924.73
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	1,703,523.00	1,703,523.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	93,094,515.00	1,703,523.00	(46,013,590.27)	48,784,447.73
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(9,473,077.03)	(9,473,077.03)
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	161,183,515.00	131,864.00	186,875,755.26	348,191,134.26
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	161,183,515.00	131,864.00	186,875,755.26	348,191,134.26
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	161,183,515.00	131,864.00	186,875,755.25	348,191,134.25
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	42,176,186.76	42,176,186.76
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	161,183,515.00	131,864.00	229,051,942.01	390,367,321.01

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	926,379,400.00	786,520,228.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	926,379,400.00	786,520,228.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	918,379,400.00	778,548,652.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	324,441,000.00	315,661,489.25
210101	Үндсэн цалин	236,200,000.00	235,434,150.97
210102	Нэмэгдэл	57,925,000.00	49,631,559.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,316,000.00	11,288,269.65
210104	Урамшуулал	20,000,000.00	19,307,508.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,555,100.00	39,111,711.49
210201	Тэтгэврийн даатгал	27,577,500.00	27,109,790.22
210202	Тэтгэмжийн даатгал	3,244,400.00	3,186,247.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,595,500.00	2,556,629.66
210204	Ажилгүйдлийн даатгал	648,900.00	569,004.08
210205	Эрүүл мэндийн даатгал	6,488,800.00	5,690,040.37
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,035,300.00	11,796,869.00
210301	Гэрэл, цахилгаан	2,500,000.00	625,699.00
210302	Түлш, халаалт	9,875,300.00	9,875,250.00
210303	Цэвэр, бохир ус	3,300,000.00	935,920.00
210304	Байрны түрээс	360,000.00	360,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,231,700.00	9,218,283.00
210401	Бичиг хэрэг	2,538,800.00	2,538,384.00
210402	Тээвэр, шатахуун	4,524,400.00	4,511,425.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,045,000.00	1,044,984.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,123,500.00	1,123,490.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,265,000.00	9,281,470.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,265,000.00	289,000.00
210604	Урсгал засвар	9,000,000.00	8,992,470.00
2107	Томилолт, зочны зардал	4,352,000.00	4,352,000.00
210702	Дотоод албан томилолт	4,352,000.00	4,352,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,529,300.00	5,033,299.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,100,000.00	4,100,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	350,000.00	350,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	129,400.00	128,525.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,495,000.00	-
210807	Газрын төлбөр	432,900.00	432,774.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	500,970,000.00	384,093,531.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	500,600,000.00	383,723,531.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	370,000.00	370,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,000,000.00	7,971,576.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,000,000.00	7,971,576.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,000,000.00	7,971,576.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	926,379,400.00	855,426,400.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	926,379,400.00	855,426,400.00
132001	Орон нутгийн төсвөөс	926,379,400.00	855,426,400.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	22,743,050.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	22,743,050.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,743,050.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,890,200.00
210401	Бичиг хэрэг	143,000.00
210402	Тээвэр, шатахуун	6,747,200.00
2107	Томилолт, зочны зардал	5,878,000.00
210702	Дотоод албан томилолт	5,878,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,200,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,200,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,774,850.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,774,850.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	22,769,139.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	22,769,139.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	20,062,539.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,706,600.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Байгууллагын зорилго: Байгальд ээлтэй ногоон хөгжлийг эрхэмлэн, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, иргэд, байгууллагыг салбарын чиг үүрэг, удирдлага арга зүйгээр хангахад оршино.

Зорилтууд:

- Байгалийн баялгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, бодлогын уялдааг сайжруулж, экологийн баримжаатай нийгэм, эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлнэ.
- Байгаль орчинтой холбоотой мэдээллийг нээлттэй, хүртээмжтэй болгож, байгаль хамгаалахад иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлнэ.

Чиг үүрэг: Аймгийн Засаг даргын 2016 оны 01 дүгээр сарын 18-ний өдрийн А/18 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралтаар БОАЖГ-ын ажилтнуудын чиг үүргийг тодорхой зааж өгчээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө дунд зэрэг байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймаг дахь Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймаг дахь Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 42,176.2 мянган төгрөгөөр буюу 12.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	5000,0	-	(5000.0)
Бараа материал	12,464.1	21,931.2	9,467.1
Үндсэн хөрөнгө	330,727.0	368,436.2	37,709.2
Нийт хөрөнгө	348,191.1	390,367.3	42,176.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	348,191.1	390,367.3	42,176.2
	348,191.1	390,367.3	42,176.2

- Авлага дансны үлдэгдэл 5.0 сая төгрөгөөр буурсан нь “Сүхбаатар-ойжуулалт” сум дундын ойн ангитай “Ойн зурвас байгуулах ажлын гэрээ”-г 2022 онд ковидын улмаас хийгдээгүй байсныг тайлант онд гүйцэтгэсэн нь нөлөөлжээ.
- Бараа материалын дансны үлдэгдэл 21,931.2 мянган төгрөг болж 9,467.1 мянган төгрөгөөр өссөн байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 368,436.2 мянган төгрөг болж 37,709.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Төсвийн хөрөнгөөр 5,920.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 48,156.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 8,286.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 1,995.0 мянган төгрөгийн программ хангамж худалдан авсан, дахин үнэлсэн 11,430.0 мянга нийт 75,787.0 нэмэгдэж, 27,371.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө данснаас хассан байна.
- Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 889,659.0 мянган төгрөг буюу 24.4 хувиар нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал санхүүжилт, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого данс байна. Тодруулбал тайланд онд Санхүүжилт 271,400.0 мянга / байгалийн нөөц ашигласны төлбөр буюу ус ашигласны төлбөрийн орлого/, үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө 11,430.0 /дахин үнэлсэн хөрөнгө/ мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 969,694.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 969,694.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 64,290.3 мянган төгрөгөөр бууруулж, 905,404.1 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхэд орон нутгийн төсвөөс 487,166.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөсөн.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 855,426.4 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 4,549.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 850,977.2 мянган төгрөг буюу 99.5 хувьтай зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/ мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101- Үндсэн үйл ажиллагаа	387,104.1	386,961.3	242.8	99.9%
2	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал дэмжлэг	8000.0	7971.6	28.4	99.6%
3	80111- Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	17,598.3	16,434.8	1.163.5	93.4%
4	81549-Ахмадын сан	600.0	600.0		100%
5	81701-Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал	442,124.0	439,009.5	3,114.5	99.3%
НИЙТ		855,426.4	850,977.2	4,549.2	99.5%

Үндсэн үйл ажиллагааны арга хэмжээний зардлын гүйцэтгэл 99.5 хувьтай хэрэгжсэн нь байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ болон тогтмол, бусад зардлууд 4,549.2 мянган төгрөгөөр хэмнэгдэж, дээд шатны төсөвт төвлөрүүлсэн.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн ЗДНС-аас санхүүгийн дэмжлэгээр 22,769.1 мянган төгрөгийн орлого төвлөрч, гүйцэтгэлээр 22,743.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулалтыг авч үзвэл бараа материал худалдан авахад 6,890.2, бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардалд 8,200.0, дотоод албан томилолт 5,878.0, бараа ажил үйлчилгээний зардалд 1,774.8 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитор А.Мөнхцэцэг, гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 16 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын 724,634.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 10,869.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1¹, 15.2.3²-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд уг зардлууд 1,824.8-99,183.2 мянган төгрөгөөр өссөн байна. Тухайлбал: Цалин хөлс болон нэмэгдэл урамшил 14,236.3, түлш халаалтын зардал 2,842.8, тээвэр шатахууны зардал 4,080.1, урсгал зардал 8,692.5, дотоод томилолт 6,097.6 мянга, хичээл үйлдвэрлэл 1,824.8 мянга, бараа үйлчилгээний зардал 99,183.2 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Үүнд:

- Цалингийн нэмэгдэл, НДШ: Төрийн үйлчилгээ, төрийн захиргааны ажилтны цалингийн нэмэгдэл гол нөлөөлсөн.
- Бараа үйлчилгээний бусад зардал: Тухайн байгууллага Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого /усны нөөц ашигласны төлбөрийн орлого / нэмэгдсэн нь нөлөөлсөн.
- Тээвэр шатахууны зардал: Шатах тослох материалын үнэ өмнөх оноос дунжаар 52.0 хувиар нэмэгдсэн нь нөлөөлөл үзүүлсэн байна.

¹ байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

² сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудаст 271,161.4 мянган төгрөгийн 10 мэдээлээгүй байгаа байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.3³, 6 дугаар зүйлийн 6.4⁴. заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг зөрчсөн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3 Зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт /мянган төгрөгөөр/		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	-	1	0	100%
Нийт дүн	1		1		

³ тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх

⁴ цалингийн зардлаас бусад таван мянган төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;/

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 102,196.8 мянган төгрөгийн 3 зөрчил илэрснээс 1,493.5 мянган төгрөгийн зөрчил⁵ илэрч төлбөрийн акт тогтоож, 100,703.3 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өглөө.

5.1 Төлбөрийн акт

- Баруун-Урт сумын төвийн “Ногоон байгууламжийг хамгаалах хашааг 6 км газарт хийх” төсөл арга хэмжээний зураг, төсөл, техникийн хяналт тавих зардлын санхүүжилт 1,493,551 төгрөгийг гүйцэтгэгч компанид илүү шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6⁶, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн 41.2.3⁷, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 2.3.2.5⁸-т заасныг зөрчсөнд төлбөрийн акт тогтоолоо.

5.2 Албан шаардлага

- Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний жагсаалтад зураг, төсөл батлагдаагүй 100,703.3 мянган төгрөгийн 2 төсөл арга хэмжээг гүйцэтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйлийн 29^{1.2.2}⁹, ТБОНӨХБАҮХАТ хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6¹⁰, Барилгын тухай хуулийн 4.1.1¹¹, 40 дүгээр зүйлийн 40.2¹², Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.2.1¹³ заалтуудыг тус тус зөрчсөн.

- Шилэн дансны цахим хуудаст 271,161.4 мянган төгрөгийн 10 мэдээллийг мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.3-т заасан “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам” -ыг зөрчсөн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3¹⁴, 6 дугаар зүйлийн 6.4.5¹⁵ заалтуудын зөрчсөнд албан шаардлага хүргүүлээ.

⁵ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл

⁶ Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ;/

⁷ төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;

⁸ барилга байгууламжийн зураг төслийн үнэ, захиалагчийн хяналтын зардал, зохиогчийн хяналтын зардал, нормчлолын сангийн зардал, чанарын баталгаат хугацааны барьцааг тус тусын дансанд холбогдох баримт бичиг, тоног төхөөрөмж хүлээн авсан акт зэргийг үндэслэн шилжүүлэх;

⁹ барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх/

¹⁰ гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд оруулах/

¹¹ /"барилгын ажил" гэж бүх төрлийн барилга байгууламжийн ажлыг гүйцэтгэх талбайг бэлтгэх, бүрдэл хэсгийг угсрах, шинэчлэн барих, буулгах, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулах үйл ажиллагааг/

¹² /Барилгын ажлыг зураг төсөлгүйгээр гүйцэтгэхийг хориглоно/

¹³ /Барилга байгууламжийн ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт нь Барилгын тухай хууль болон холбогдох дүрэм, журам, норм, стандартад нийцсэн байна

¹⁴ / тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх /

¹⁵ /цалингийн зардлаас бусад таван мянган төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Тээвэр, шатахууны зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Албан ажлын автомашинуудад мэдээлэл, хяналтын төхөөрөмж буюу GPS суурилуулаагүй нь Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, сангийн сайдын 2022.12.23-ны өдрийн 95/260 дугаартай хамтарсан тушаалаар батлагдсан "Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам"-ын 4.2 дахь "Алба ажлын автомашин нь Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS 4598 стандартын шаардлагыг хангасан байна." заалт, Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS 4598 стандартын 8.4.3, 11.1 дэх заалттай нийцэхгүй байна. Албан ажлын автомашинуудад GPS суурилуулаагүй нь шатахууны зардалд хэмнэлт бий болохгүй байх сөрөг үр дагавартай байна.

Өгсөн зөвлөмж:

Албан ажлын автомашинуудад MNS 4598 стандартад заасан мэдээлэл, хяналтын төхөөрөмж буюу GPS суурилуулж, жолоочийн тооцооны хуудаст автомашины явсан маршрутыг жолоочоор GPS-ийн мэдээлэлд үндэслэн дэлгэрэнгүй бичүүлж, хяналт тавьж, шатахууны зардалд хэмнэлт бий болгож ажиллах.

2. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас хийгдсэн төсөл, арга хэмжээг данс бүртгэлд тусгаагүй, ашиглагч байгууллагад шилжүүлэх, бүртгэлээр тавих хяналт хэрэгжээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 37.1.7-д “төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу холбогдох дансанд бүртгэх, тайлагнах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6.2 “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна”, 25.1 “Төрийн өмчийн эд хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан журмаар үнэлж бүртгэнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ” заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Захиалагч төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг Төрийн болон орон нутгийн өмчийн, НББ-ийн тухай хуулийн хүрээнд ашиглагч байгууллагад шилжүүлэх асуудлыг эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлж, хүлээлгэн өгч байх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/												
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төсөл арга хэмжээний зураг, төсөл, техникийн хяналт тавих зардлын санхүүжилтийг гүйцэтгэгч компанид илүү шилжүүлсэн байна.	1	1,493.5	1	1,493.5								
Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 2 төсөл, арга хэмжээний ажлыг зураг төсөлгүй гүйцэтгэсэн байна.	1	100,703.3			1	100,703.3						
Албан ажлын автомашинуудад мэдээлэл, хяналтын төхөөрөмж буюу GPS суурилуулаагүй	1						1					
Захиалагч төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг Төрийн болон орон нутгийн өмчийн, НББ-ийн тухай хуулийн хүрээнд ашиглагч байгууллагад шилжүүлэх асуудлыг эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлж, хүлээлгэн өгч байх	1						1					
Дүн	4	102,196.8	1	1,493.5	1	100,703.3	2					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/ мянган төгрөгөөр/									
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шилэн дансны нэгдсэн сайтад оруулах мэдээллээс таван сая төгрөгөөс дээш үнийн дүнгийн урсгал санхүүжилтийн мэдээлээгүй	1	-	-	-	1	-			-
Дүн		-	-	-	1	-			